

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв, эх үүсвэр /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2024он)	Зорилтот түвшин (2025он)	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл ийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Ажил эрхэлдэггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг түр хоноглох үйлчилгээнд хамруулж, амьдралын зөв дадал хэвшилд сургах, ажлын байранд зуучлах үйлчилгээ үзүүлж орлоготой болоход нь дэмжлэг үзүүлнэ. (НЗДҮАХ 2.3.1)							
1	Зорилт 1.1. Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах.		Гүйцэтгэлийн хувь	-	100	Стратеги төлөвлөгөө боловсруулах тухай Нийслэлийн ЗДТГ-ын ТЗУГ-аас зохион байгуулсан сургалтад төвөөс 2 ажилтан хамрагдаж, зөвлөмжийн дагуу байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн ЗДТГ-ын газар, хэлтсүүдээр хянуулж, Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. Шинээр батлуулсан стратеги төлөвлөгөөг төвийн албан хаагчдад танилцуулан, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтуудыг байгууллагын жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажилласан.	100
2	Зорилт 1.2. Шинээр ашиглалтад орох Сургалт хүмүүжлийн цогцолбор төвд шаардлагатай бүтэц орон тоо, тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг холбогдох байгууллагад уламжлах.	НХТЖҮЧ 3.1.1; 3.2.1 3,000.0	Гүйцэтгэлийн хувь	95	100	Цогцолбор төвд шаардлагатай бүтэц орон тоо, тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг Нийслэлийн ЗДТГ-т хүргүүлж ажилласны дагуу Нийслэлийн Засаг Даргын А/158 захирамжаар төвийн бүтэц орон тоо, А/430 захирамжаар тоног төхөөрөмжийн шаардлагатай төсөв тус тус батлагдсан бөгөөд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт тоног төхөөрөмж худалдан авах тендертэй холбоотой техникийн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар тоног төхөөрөмж худалдан авах ажлыг зохион байгуулж, “Интерворлд” ХХК тендерт шалгарч, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт 80%-тай үргэлжилж байна. Мөн дотоодоос худалдан авах тоног төхөөрөмжийн бага үнийн дүн бүхий тендер оролцогчгүй 4 дэх удаагаа зарлагдаж, үндэсний үйлдвэрлэгч Чиглэл ХХК шалгарч, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын бэлтгэл ажил хангагдаж байна. Дээрх тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил 2025 оны 12 сарын 25-ний өдөрт багтааж нийлүүлэлт, угсралт суурилуулалт бүрэн гүйцэтгүүлнэ.	100

3	Зорилт 1.3. Сургалт хүмүүжлийн цогцолбор төвийг ашиглалтад оруулж, зорилтот бүлгийн иргэдийг хүлээн авч нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлж эхлэх.	НХТЖҮЧ 3.1.1; 3.2.2 1,600.0	Гүйцэтгэлийн хувь	20	100	Нийгмийн бодлогын газрын мэргэжилтэн М.Намсрайхүү 01 сарын 16-нд, Нийслэлийн Санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл хөтөлбөрийн зохицуулагч Л.Хосбаяр 07 сарын 25нд, Нийгмийн бодлогын газрын дарга Ш.Анхмаа 10 сарын 13-ний өдөр барилгын талбайд тус тус зочилж, гүйцэтгэгч талд ажил эрчимжүүлэх тухай чиглэл өгч ажилласан. Барилгын гүйцэтгэгч Тэмээн ХХК нь одоогийн байдлаар барилгын ажлын гүйцэтгэлийг дуусгах шатанд хүргэж, комисс ажиллуулах хүсэлтээ хүргүүлсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сард багтаан ашиглагч талд бүрэн хүлээлгэн өгөхөө мэдэгдсэн. Барилгын гүйцэтгэгч Тэмээн ХХК-д хүсэлт тавьсны дагуу 1м диаметртэй босоо 3 кольцоо, 4 тасалгаа бүхий нийт 12 кольцоотой нөөцийн бие засах газрын материалын зардлыг 100% шийдэж, техник тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлж, тусгай төвийн ажилтнууд барилгын ажлыг гүйцэтгэж бие засах газрыг ашиглалтад оруулсан. Түүнчлэн цогцолбор төв ашиглалтад орж, зорилтот бүлгийн иргэдийг хүлээн авч эхлэхтэй холбоотой бэлтгэн ажлыг ханган ажиллаж байна.	95
4	Зорилт 1.4. Гэр оронгүй иргэдтэй ажиллах арга зүй, нийгэмшүүлэх сургалт, хөгжлийн цогц хөтөлбөр, гарын авлага боловсруулах.		Гүйцэтгэлийн хувь	10	100	“Гэр оронгүй иргэдтэй ажиллах арга зүй” гарын авлага боловсруулах ажлын хүрээнд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, эмч, хуульч нар хамтран 4 удаагийн төлөвлөгөөт уулзалт хийсэн ба ажлын гүйцэтгэлийг ханган ажиллаж байна. Үүнд: 1.Ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. 2.Номын агуулгыг боловсруулан гаргаж, хуваарилалт хийсэн. 3.Ном бичих стандартыг хялбаршуулан боловсруулж, ажлын хэсэгт танилцуулсан. 4.Арга зүйн боловсруулалтын ажил 50%-тай үргэлжилж байгаа бөгөөд 2026 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.	85
5	Зорилт 1.5. Сургалт хүмүүжлийн цогцолбор төвийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дараагийн шатны зураг төслийн ажлыг гүйцэтгүүлэх.		Гүйцэтгэлийн хувь	10	100	Цогцолбор төвийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дараагийн шатны зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд зургийн архитектор төлөвлөлтийн даалгаврыг Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газраар гаргуулахаар зөвлөгөө авч ажилласан бөгөөд захиалагч талын тодорхойлолтыг боловсруулан тус байгуулагд хүргүүлж ажилласан.	85

6	Зорилт 1.6. Сургалт хүмүүжлийн цогцолбор төвийг түшиглэсэн “Жимс жимсгэнийн аж ахуй байгуулах” төсөл хэрэгжүүлэх.		Гүйцэтгэлийн хувь	30	80	Канадын ЭСЯ, Канад сангаас 2025-2026 онд зарласан төслийн уралдаанд Жимс, жимгэсний аж ахуй байгуулах төслийн санал боловсруулан хүргүүлсэн боловч төсөл дэмжигдээгүй байна. Төслийн санхүүжилтийг бүрдүүлэх дараагийн шатны төлөвлөлт гаргаж НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй Даян дэлхийн байгаль орчны сангийн төслийн уралдаанд төр, хувийн хэвшил, түншлэлийн хүрээнд уг төслийг шинэчлэн боловсруулж хүргүүлэхээр ажиллаж байна.	85
7	Зорилт 1.7. Сургалт хүмүүжлийн цогцолбор төвийг түшиглэн “Төмс, хүнсний ногоо тариалах” төсөл боловсруулж хэрэгжүүлэх.		Гүйцэтгэлийн хувь	10	100	Цогцолбор төвийн дэргэдэх 3,2 га газрыг хашаалж, салхины хаалт хийж мод тарих, ногоо тарих талбайг бэлтгэх, газар тэгшлэх ажлуудыг гүйцэтгэн ажилласан. Түүнчлэн талбайн салхины хүчийг бууруулах зорилгоор хамгаалалтын зурвас үүсгэж 180ш 2-3м өндөртэй улиас тарьсан. Санхүүжилтийн хүндрэлээс шалтгаалан хүнсний ногоо, хүлэмжийн нарийн ногоо тариалах ажлыг 2026 онд гүйцэтгэхээр гарц гаргалгаа судлан ажиллаж байна.	90
8	Зорилт 1.8. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд: Сургалт хүмүүжлийн цогцолбор төвийг түшиглэн хэрэгжих “Мод үржүүлгийн газар байгуулах” төсөл боловсруулж, хэрэгжүүлэх.		Гүйцэтгэлийн хувь	30	80	Төсөл хэрэгжүүлэх талбайг хашаалж, газар тэгшлэх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд төслийн баримт бичиг боловсруулж, хөрсний судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Санхүүжилтийн хүндрэлээс шалтгаалан мод үржүүлгийн газар байгуулах ажлыг 2026 онд гүйцэтгэхээр гарц гаргалгаа судлан ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Тэрбум мод” санаачилгын хүрээнд Хаврын мод тарих өдрүүдийг тохиолдуулан төвийн ажилтнуудын төлөөлөл 2022 онд ХУД, 14-р хороо, Айцын аманд улиас, хайлаас, голт бор зэрэг 39ш суулгац тарьсан бөгөөд хуваарийн дагуу тарьсан модоо усалж арчилсан. Налайх Дүүргийн ЗДТГ-аас ирсэн албан бичгийн дагуу Шинэ налайх цэцэрлэгт хүрээлэнд 15ш буйлс, Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбороос ирсэн албан бичгийн дагуу төвөөр үйлчлүүлэгч иргэд, албан хаагчид 2 өдөр ажиллаж 250 модны нүх ухаж, тарьж, усалж гүйцэтгэсэн байна. Түүнчлэн Төвийн албан хаагчид, үйлчлүүлэгч иргэд хамтран 2025 оны намрын мод тарих өдрүүдийг тохиолдуулан Сургалт хөгжлийн цогцолбор төвийн хүлэмж, жимгэсний аж ахуйн талбайд 3м өндөртэй улиас 180ш, оффисын талбайд 1,5м өндөртэй мөнх ногоон гацуур 3ш нийт 183 мод суулгаж, усалгаа арчилгааг гүйцэтгэн ажилласан.	88

Стратеги төлөвлөгөөний зорилго 2: Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг нутаг дэвсгэрийн нэгж бүрд төр хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлийн боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлж, хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлнэ. (НЗДҮАХ 2.5.1)

9	Зорилт 2.1. Орон гэргүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд цахим сэтгэл зүйн зөвлөгөөг зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх.		Хамрагдсан хүний тоо	11	80	Төвийн цахим хуудас болон нүүр номын хуудаас зайн сэтгэл зүйн зөвлөгөөний зар байршуулан ажилласан бөгөөд цахим сэтгэл зүйн зөвлөгөөг 82 хүнд үзүүлсэн. Үүнд утсаар 23, цахим платформоор 59 үйлчлүүлэгчид хүргэсэн бөгөөд донтолтын асуудал, гэр бүлийн харилцаа, харилцааны зөрчил, ганцаардал, шинэ орчны стресс, гэмт хэрэгт холбогдсон зэрэг асуудлаар хандсан байна.	100
10	Зорилт 2.2. Орон гэргүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх зорилтын хүрээнд дүүргүүдийн ЗДТГ-тай хамтран Нийгмийн хөгжлийн хэлтэс, хорооны холбогдох ажилтнуудад сургалт зохион байгуулж, мэдээллээр хангаж ажиллах.		Зохион байгуулах сургалтын тоо	3	9	Нийслэлийн төвийн 6 дүүргийн ЗДТГ-т Гэр оронгүй иргэдэд үзүүлж буй хүртээмжийн талаарх зөвлөлдөх уулзалт, сургалт хийх тухай албан бичиг 11 дүгээр сарын 24-ний өдөр хүргүүлсэн. Албан бичгийн хүрээнд зөвлөлдөх уулзалт, сургалтыг 12 дугаар сарын 2 дахь 7 хоногт зохион байгуулахаар хуваарь, төлөвлөлт хийгдсэн. Энэхүү зөвлөлдөх уулзалт, сургалтын хүрээнд шинээр ашиглалтад орж буй Сургалт хөгжлийн цогцолбор төвийн үйл ажиллагаа, болон одоогийн Түр хоноглох төвийн үйл ажиллагааны өөрчлөлт шинэчлэлт, зорилтот бүлгийн иргэдийг ямар шатлалаар, хэрхэн хүлээн авч үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эргэх холбоог сайжруулах тухай сургалт, танилцуулга хийж ажиллах юм.	96

Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

3.1. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах

11	Зорилт 3.1.1. Ажлын байрны сул орон тоог төвийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлаж, сонгон шалгаруулалт, хүний нөөцийн бүрдүүлэлтийг тухай бүр хийж ажиллах.		Хэрэгжилтийн хувь	100	100	Нэн шаардлагатай жижүүр, хууль эрх зүйн ажилтны 5 орон тоон дээр ажлын байрыг төвийн цахим хуудсаар дамжуулан зарлаж, хүний нөөцийн бүрдүүлэлт хийж, иргэдтэй шууд тулж ажилладаггүй сул орон тоог бусад ажилтанд чиг үүргийг хуваарилан ажилласан. Нэмэгдсэн бүтцийн хүрээнд нэг, хоёрдугаар ээлжийн шалгаруулалтын 29 ажлын байранд бүрдүүлэлт хийсэн байна. Түүнчлэн хүйтний улиралд байгууллагын ачаалал эрс нэмэгдэж буй нөхцөл байдалтай холбогдуулан НЗДТГ-т 6 сул орон тоон дээр нөхөн бүрдүүлэлт хийх гарцаагүй шаардлага үүсэж буй тухай албан бичиг хүргүүлэн нөхөн бүрдүүлэлт хийж ажиллаж байна.	100
----	--	--	-------------------	-----	-----	---	-----

12	Зорилт 3.1.2. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг ханган, үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэн улирал бүр ур чадварын нэмэгдэл, хагас, бүтэн жилээр үр дүнгийн урамшуулал олгож, хэрэгжилтийг ханган ажиллах.		Хэрэгжилтийн хувь	100	100	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг ханган, ур чадвар, үр дүнг олгох журмын дагуу 1,2,3,4 дүгээр улиралд ажилтнуудын тайланд үндэслэн ур чадвар, үр дүнгийн урамшууллыг давхардсан тоогоор 114 албан хаагчдад олгосон бөгөөд сүүлийн хагас жилийн үр дүнгийн урамшуулал олгох үнэлгээг хийж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	100
13	Зорилт 3.1.3. Хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөний дагуу мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хүрээнд албан хаагчдыг сургалт хөгжлийн үйл ажиллагаанд хамруулж, мэргэжлээ дээшлүүлэх чиглэлээр суралцахад нь ажлын цагийн зохицуулалт хийж дэмжлэг үзүүлэх.		Хэрэгжилтийн хувь	100	100	“Хүний нөөцийн хөгжлийн төв”-өөс зохион байгуулсан 19 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 27 ажилтан, 46 цагийн хувь хүний хөгжлийн сургалтад, албан бичгийн дагуу мэргэжлийн чиглэлээр 8 сургалтад 14 ажилтан 38 цагийн сургалтад тус тус хамрагдсан байна. Дотооддоо зохион байгуулсан 17 удаагийн 19 цаг 30 минутын сургалтад давхардсан тоогоор 203 ажилтан хамрагдсан. Тайлангийн хугацаанд нийт 44 удаагийн сургалтад давхардсан тоогоор 244 ажилтан 103 цагийн сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа хөгжүүлсэн байна.	100
14	Зорилт 3.1.4. Байгууллагын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан зарим ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, шинээр ажилд орж буй ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж ажиллах.		Хэрэгжилтийн хувь	100	100	1.Шинэ бүтэц орон тоотой холбоотой цогцолбор төвийн албан тушаалын 14 тодорхойлолтыг ажлын хэсэг боловсруулж, батлуулсан. 2.Засгийн Газрын 238 дугаар тогтоолын хүрээнд төвийн даргын тушаалаар нийт 30 ажилтны хөдөлмөрийн гэрээний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулсан. 3.Шинээр орсон 29 ажилтанд байгууллагын үйл ажиллагаа, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргийг танилцуулж ажилласан.	100
15	Зорилт 3.1.5. Гадаад улсад адил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж ажилтнуудыг туршлага судлуулах.		Ажилтны тоогоор	5	5	Төвийн хүний нөөцийн ажилтан Нийслэлийн ЗДТГ, Дезерет олон улсын байгууллагын дэмжлэгээр Америкийн нэгдсэн улсад Нийтийн удирдлагын чиглэлээр 80 цагийн сургалтад хамрагдсан нь шинээр ашиглалтад орох Сургалт хөгжлийн цогцолбор төвийн үйл ажиллагааг төлөвлөхөд чухал үр дүнтэй байв. Түүнчлэн БНСУ, АНУ-руу төвийн 2 ажилтан хувийн зардлаар мэргэжлээрээ богино хугацаатай туршлага судлан ажилласан.	95

						Төвийн ажилтнуудын төлөөлөл “Нархан” хүүхдийн асрамжийн газар гэр хотхоны үйл ажиллагаатай танилцаж хүүхдүүдэд хичээлийн хэрэгсэл болон дулаан хувцас зэргийг хандивлан хамтран ажилласан. Мөн албан хаагчдын төлөөлөл ХААИС-ийн дэргэдэх "Ухаалаг хүлэмжийн аж ахуйн төв" сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашигласан гидропон технологи бүхий бүрэн автомат хүлэмжийн аж ахуйн төвтэй танилцан санал, туршлага солилцсон.	
3.2. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах							
16	Зорилт 3.2.1 “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны төлөвлөгөө” боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллах.		Хэрэгжилтийн хувь	100	100	Нийгмийн баталгааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.Үүнд: 1.Ажилтны нийгмийн баталгааг хангахад, дотоод журмын дагуу 9 ажилтанд нүүрс түлээний 900,000 төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан. 2.Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд нийт 16 ажилтныг хөдөлмөрийн дотоод журмын дагуу сургалт, эрүүл мэнд, гадаадад туршлага судлах чиглэлд цалинтай дэмжлэг үзүүлсэн байна. 3.Ажилтнуудын ажлын байрны нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2022-2024 оныг харьцуулсан судалгааг хийж үр дүнг тайлагнасан. 4.Төвөөс тэтгэвэрт гарсан 6 ажилтанд цагаан сар, ахмадын баярын хүндэтгэл үзүүлэн хөдөлмөрийн дотоод журмын дагуу 1,800,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 5.Ажилтнуудын амьдарч буй орон байрны судалгааг шинэчилж, албан хаагчдын нас хүйсийн тэнцвэрт байдлын судалгааг гаргасан. 6.Олон улсын Ахмадын баярыг угтан төвийн нийт 9 ахмад настныг хөтөлбөрийн дагуу хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. 7.Тэтгэвэрт гаргах албан хаагчдад “Тэтгэвэрт гарах үеийн нийгэм сэтгэл зүйн бэлтгэл” сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. 8. ТОСК-д нийт ажилтнуудын амьдарч буй сууцны талаарх судалгаа, албан хаагчдын хүсэлтийн дагуу шаардлагатай албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөл бүхий орон сууцад хамруулах хүсэлт хүргүүлэн ажилласан боловч шийдэгдээгүй.	95

17	Зорилт 3.2.2. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж ажиллах		Хэрэгжилтийн хувь	100	100	Монгол Японы хамтарсан эмнэлэгтэй хамтран ажиллаж, урьдчилан сэргийлэх үзлэг, нарийн мэргэжлийн шинжилгээнд төвийн 25 албан хаагчийг хамруулан ажилласан. Ажилтан албан хаагчдыг төвийн сэтгэцийн эмч сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгт хамруулан ажилласан. Төвийн ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор СХД-н сэтгэл зүйчтэй хамтран сургалт зохион байгуулсан. Албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор төвийн сэтгэл зүйч нар албан хаагчдад ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээг зохион байгуулсан нь албан хаагчдын ажлын байран дээрх сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн, үр дүнтэй ажил болсон.	100
18	Зорилт 3.2.3. Байгууллагын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийн санаачилга, төлөвлөгөөг дэмжиж, хэрэгжүүлэх.		Хэрэгжилтийн хувь	100	100	2025 онд хэрэгжүүлэх эцэг эхийн зөвлөлийн ажлын 2 чиглэлээр 11 багц ажлыг төлөвлөн батлуулсан. Төлөвлөгөөний дагуу ажилтнуудын хүүхдийн судалгааг гаргасан бөгөөд 0-18 насны 48 хүүхэд байна. Ажилдаа ирэх, тарах цагт хүүхдээ цэцэрлэгт хүргэдэг 5 ажилтанд ажлын цагийн зохицуулалт хийгдэн, 0-16 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эхэд хүүхдийнх нь төрсөн өдрөөр чөлөө өгөх ажилд тайлант хугацаанд 12 ажилтан хамрагдсан байна. Дэлхийн гэр бүлийн өдрийг угтан “Бүх хайраа гэр бүлдээ” арга хэмжээнд 30 ажилтан, Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 30 хүүхдэд бэлэг олгох ажлуудыг зохион байгуулсан. Эдгээр хэрэгжүүлсэн ажлууд нь ажилтнуудын урам зориг, ажлын байрны стресс буурах боломж нөхцөлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.	100
19	Зорилт 3.2.4. Байгууллагын дэргэдэх Спорт хамтлаг, Залуучуудын зөвлөлийн санаачилга, төлөвлөгөөг дэмжиж, хэрэгжүүлэх.		Хэрэгжилтийн хувь	100	100	Төлөвлөгөөний хүрээнд албан хаагчдын дунд нөхөрсөг спортын арга хэмжээг 2 удаа, албан хаагчдын дархлаа болон хөдөлгөөнийг дэмжих өглөөний эко алхалтыг 5 удаа тус тус зохион байгуулсан. “Улаанбаатар-Марафон” арга хэмжээнд нийт албан хаагчид 5км-ийн гүйлтэд идэвхтэй оролцсон байна. Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвөөс санаачлан 09 дүгээр сарын 27-ны өдөр Нийслэлийн харьяа 6 байгууллагын дунд зохион байгуулсан спортын нөхөрсөг тэмцээнд төвийн албан хаагчид идэвхтэй оролцсон. Гар бөмбөг, сагс, дартс, ширээний теннис зэрэг спортын 4 төрөлд 6 баг оролцож, нэг өдрийг спортоор хичээллэж, дасгал хөдөлгөөнийг дэмжиж өнгөрүүлсэн нь спортыг дэмжсэн, үр дүнтэй ажил болсон.	100

20	Зорилт 3.2.5. Сургалт хүмүүжлийн цогцолбор төв хотын төвлөрсөн дэд бүтэц, нийтийн тээврийн маршрутаас алслагдсан тул тус төвд ажиллах албан хаагчдад Гачууртын чиглэлд газар эзэмшүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлэх.		Шийдвэрийн тоо	-	1	Шинээр ашиглалтад орох сургалт хөгжлийн цогцолбор төв, Нийслэлийн төвлөрлийг сааруулах бодлого, төвийн албан хаагчдын нийгмийн баталгааг дэмжих зорилтын хүрээнд албан хаагчдад Гачуурт чиглэлд газар эзэмшүүлэх талаар албан бичиг, хүсэлтийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэн ажилласан боловч шийдвэрлэх боломжгүй тухай хариу ирүүлсэн. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас Нийслэлийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байршилд, Нийслэлийн Засаг дарга шийдвэрлэх тухай зөвлөмжийн дагуу 2026 онд албан хаагчдад газар эзэмшүүлэх ажлыг үргэлжлүүлэн судалж, хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.	85
3.3. Мэдээллийн ил тод байдлыг хангах							
21	Зорилт 3.3.1. Төвийн худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны /tender.gov.mn/ цахим системээр зохион байгуулах.		Тендер зарлах багцын тоо	6	6	Хүнсний материал худалдан авах нээлттэй тендер шалгаруулалт-1, харьцуулалтын аргаар-2 багцад тендер зохион байгуулагдсан. 1 багцад төрийн цахим дэлгүүрээс худалдан авалт хийж байна. Мах махан бүтээгдэхүүн нийлүүлэх Нээлттэй тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулагдаж бэлтгэн нийлүүлэгч сонгогдон гэрээ байгуулан худалдан авалтаа хийж байна. Харьцуулалтын аргаар зохион байгуулсан 2 тендер шалгаруулалт амжилтгүй болж дахин зарлагдсан. 2 дахь удаагийн тендер шалгаруулалтаар хүнсний ногоо нийлүүлэх тендер амжилттай болж бэлтгэн нийлүүлэгч сонгогдон гэрээ байгуулан ажиллаж байна. Нээлттэй Шууд худалдан авалтаар 3 багцад үнийн санал ирүүлэх урилга нийтэлсэн. Мөн Амжилтгүй болсон гурил, гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх тендерийг цаашид шууд худалдан авалтаар зохион байгуулахаар үнэлгээний хорооноос шийдвэр гарган үнийн санал ирүүлэх урилга нийтэлсэн. Нийт 4 багцын хүнсний материал нийлүүлэхээр 2 компани санал ирүүлсэн. Үнэлгээний хороо ирсэн саналуудыг үнэлж нийлүүлэгчийг сонгон гэрээ байгуулан ажиллаж байна.	100
22	Зорилт 3.3.2. Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх,	1,750.7	Тайлангийн тоо	4	4	2024 оны санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж Нийслэл дэх Төрийн аудитын газраар аудит хийлгэн өөрчлөлтгүй санал дүгнэлт авсан. 2025 онд 1,750.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. 09 дүгээр сард төсвийн тодотголоор Сургалт хөгжлийн цогцолбор төв ашиглалтад орохтой холбоотой	99

	санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, зөрчил дутагдалгүй ажиллах.					төсвийг 3,799.3 сая төгрөг болгон батлуулсан. Төсвийг зориулалтын дагуу зарцуулж 3 дугаар улирлын санхүүгийн тайлан өр, авлагагүй байсан боловч 11 дүгээр сарын байдлаар зарим зардлын төсөв татагдсантай холбоотойгоор 5,990.0 мянган төгрөгийн өр бүртгэгдсэн.	
23	Зорилт 3.3.3. Шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт төсөв санхүүтэй холбоотой мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж, тогтмол шинэчилж ажиллах.		Мэдээллийн тоо	151	171	2025 онд шилэн дансны цахим хуудсанд эхний 9 сарын байдлаар нийт НДАА-аас шилэн дансны мэдээлэлд аудит хийгдсэн. Зөрчилгүй. Эхний 11 сарын байдлаар 139 мэдээлэл нийтлэгдсэн. Мэдээллийн самбарт төсөв санхүүтэй холбоотой мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж, тогтмол шинэчилж байна.	100
24	Зорилт 3.3.4. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах.		Хэрэгжилтийн хувь	100	100	Тайлангийн хугацаанд төвийн албан хаагчдад хоёр удаа сургалт зохион байгуулж, цахим орчинд болон мэдээллийн самбарт 26 удаа мэдээлэл нийтэлж түгээсэн. СХД-ийн Цагдаагийн газрын албан хаагчдад зорилтот бүлгийн иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаар нэг удаа сургалт зохион байгуулсан.	100
25	Зорилт 3.3.5. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах.		Хэрэгжилтийн хувь	100	100	Төлөвлөгөөний дагуу 5 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулан, цахим орчинд болон мэдээллийн самбарт 22 удаа мэдээлэл нийтэлж, түгээн ажилласан байна. Ёс зүйн дэд хороонд 4 удаа гомдол ирснийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Монгол улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан “Ёс зүйн сургагч багш”-ийн үнэмлэх олгосон 32 цагийн сургалтад төвийн 2 ажилтан хамрагдаж төгсөн, байгууллагын албан хаагчдад сургалт соён гэгээрлийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
4.1. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг хэрэгжүүлэх							
26	Зорилт 4.1.1. Ажил эрхэлдэггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй, орон гэргүй иргэдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, үнэлгээний дагуу түр хоноглох байрны үйлчилгээ үзүүлэх.		Хэрэгжилтийн хувь	100	100	2025 онд 783 /давхардаагүй тоогоор/ иргэнийг хүлээн авч анхан шатны ярилцлага хийж, байрлах хүсэлтийг шийдвэрлэж ажилласан байна. Эдгээр иргэдийн ерөнхий мэдээлэлд судалгаа хийхэд 205 иргэн анх удаа бүртгэгдсэн, 578 иргэн давтан үйлчилгээ авсан байна. Зорилтот бүлгийн иргэдийг хоноглох байранд 35770 /давхардсан тоогоор/ иргэнийг хоноглуулан, 102069 /давхардсан тоогоор/ иргэнд цэсийн дагуу өдөрт 3 удаа халуун хоол цайны үйлчилгээг үзүүлсэн байна.	100

27	Зорилт 4.1.2. Үйлчлүүлэгч иргэдийн нөхцөл байдалд судалгаа хийж, бичиг баримтжуулах, хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжид хамруулах, сунгалт хийх зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах.		Хэрэгжилтийн хувь	100	100	Иргэний бичиг баримтгүй, зөрчилтэй 9 иргэний материал бүрдүүлэн холбогдох байгууллагуудад хүргүүлж, 8 иргэнийг бичиг баримтжуулсан. Мөн шинээр 7 иргэнийг тэтгэвэр тэтгэмжид хамруулан 9 иргэний тэтгэвэр, тэтгэмжийн сунгалт хийлгэж ажилласнаар тэдгээр иргэд орлогын эх үүсвэртэй болсон байна. Ахмад настай харж хандах гэр бүлгүй 10 иргэний нөхцөл байдлын үнэлгээг хийж, төрөлжсөн асрамжид шилжүүлэхээр материал бүрдүүлж, иргэний хаягийн дагуу холбогдох байгууллагад хүргүүлэн 3 иргэнийг Ахмадын асрамжид шилжүүлэн ажилласан байна. Асрамжид шилжиж буй иргэдийн тоо өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100
28	Зорилт 4.1.3. Тэнэмэл иргэд ихээр төвлөрдөг томоохон худалдааны төв, хаягдал түүхий эд худалдан авах цэгүүд гэх мэт газруудаар товлосон хугацаанд зорилтот бүлгийн иргэд, үйлчилгээний байгууллагуудад мэдээлэл түгээж ажиллах.		Зохион байгуулсан ажлын тоо	2	4	Гадуур судалгаагаар ажиллах удирдамжийн дагуу төвийн албан хаагчид 2025 оны 1, 2, 3 дугаар улиралд 3 удаагийн судалгаагаар зах худалдааны төв, хогийн цэг, олон нийтийн төвлөрсөн цэгүүдэд ажиллаж Нийслэлийн 6 дүүргийн 314 иргэн, 45 аж ахуй нэгж байгууллага, дүүргүүдийн нийгмийн хөгжлийн хэлтэст төвийн үйлчилгээний талаар мэдээлэл түгээж ажилласан. Тус ажлын үр дүнд өөрийн хүсэлтээр 32 иргэн хандан ирж үйлчилгээ авсан байна.	94
29	Зорилт 4.1.4. Өмнөх жилүүдэд бие даасан амьдралд шилжсэн иргэдтэй эргэх холбоо тогтоож, амьдралын нөхцөл, байдлыг судалж дэмжлэг шаардлагатай иргэдэд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллах.		Зөвлөгөөнд хамрагдсан иргэдийн тоо	6	25	Нийгэмшиж бие даан амьдарч буй иргэдээс 21 иргэнтэй холбоо тогтоож, тэдний амьдрал ахуй, тулгамдаж буй асуудлуудад нийгмийн ажил, сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан.	95
30	Зорилт 4.1.5. Түр хоноглох байраар үйлчлүүлж буй иргэдийг сургалт хөгжил, нийгэмшүүлэх цогц хөтөлбөрт хамруулж, бие даасан амьдралд шилжихэд нь дэмжлэг үзүүлж ажиллах.		Бие даасан амьдралд шилжсэн иргэдийн тоо	31	35	Байгууллагаар тухайн жилд үйлчлүүлсэн иргэдийн 5%-ийг бие даасан амьдралд шилжүүлэх зорилтын хүрээнд үйлчлүүлэгч иргэдийн гэр бүлийн судалгааг хийж, холбоо тогтоох, тэдний бие даан амьдрах нөхцөл боломжийг судлан гэр бүлийн гишүүдэд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж ажилласан. Тайлант хугацаанд 30 иргэнийг гэр бүлд нь хүлээлгэн өгч бие даасан амьдралд шилжүүлсэн байна.	85
31	Зорилт 4.1.6. Үйлчлүүлэгч иргэдийн үйлчилгээ авч буй орчныг сайжруулж		Хэрэгжилтийн хувь	100	100	Төвийн Түр хоноглох байрны ор, гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл, тооцоо судалгааг боловсруулж, албан бичгээр 2025 оны 02 дугаар сард	100

	байгууллагын дотоод болон гадна тохижилт, урсгал засварын ажлыг гүйцэтгэх.					Дээрэрт ОУ-ын Энэрлийн байгууллагад хүргүүлсэн бөгөөд оны төгсгөлд дээрх төсөл бүрэн хэрэгжсэн. Дээрэрт ОУ-ын Энэрлийн байгууллагын Ази тивийн бүсийн менежер, Монголын талын Олон нийттэй харилцах албаны захирал С.Насанболд, Хүмүүнлэгийн салбар хариуцсан захирал Д.Пүрэвжаргал нарын төлөөлөл 11 сарын 11-ний өдөр Тусгай төвд зочилж, талуудын төлөөлөл хоёр байгууллагын хамтран хэрэгжүүлж буй Хүмүүнлэгийн халамжийн төслийн гэрээнд гарын үсэг зурах ёслолыг зохион байгуулж, тоног төхөөрөмжийг албан ёсоор хүлээлцсэн. Төслийн хүрээнд төвийн гал тогооны тоног төхөөрөмж, үйлчлүүлэгч иргэдийн ор, ус цэвэршүүлэгч зэрэг 54,6 сая төгрөгийн үнэ бүхий 58ш тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж дэмжлэг үзүүлсэн. Тоног төхөөрөмж шинэчлэгдсэнээр зорилтот бүлгийн иргэд үйлчилгээ авдаг орчин нөхцөл сайжирч, гал тогооны аюулгүй байдал, хоолны чанар сайжирч, үйлчилгээний сэтгэл ханамж нэмэгдсэн нь төслийн гол үр дүн юм.	
4.2. Сургалт, соёл хүмүүжлийн үйлчилгээ							
32	Зорилт 4.2.1. Төвийн гүйцэтгэх ажилтнууд сургалтын төлөвлөгөөний дагуу үйлчлүүлэгч иргэдэд хувь хүний хөгжил төлөвшлийн олон талт сургалтуудыг зохион байгуулах.		Сургалтын тоо	50	60	Нийгмийн ажилтнууд болон эмч, сэтгэл зүйч нар үйлчлүүлэгч иргэдийн харилцаа хандлагыг өөрчлөх хувь хүний хөгжил төлөвшлийн болон танин мэдэхүйн холбогдолтой 61 удаагийн сургалт зохион байгуулж 1825 иргэнийг хамруулан сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийгэмд итгэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлж нийгэмшүүлэхэд чиглэн ажилласан байна.	98
33	Зорилт 4.2.2. Үйлчлүүлэгч иргэдэд "Гэгээн өглөө" уулзалтыг хуваарийн дагуу зохион байгуулж, эерэг мэдээллээр хангаж ажиллах.		Зохион байгуулсан уулзалтын тоо	230	230	"Гэгээн өглөө" уулзалтыг 230 удаа зохион байгуулж, 12650 /давхардсан тоогоор/ иргэн хамрагдсан бөгөөд тухайн өдрийн эерэг мэдээлэл, дасгал хөдөлгөөн, зохион байгуулагдах арга хэмжээ, танин мэдэхүйн зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажилласан. Төвийн дарга Ш.Мөнхцэцэгийн санаачилгын дагуу Баасан гараг бүр үйлчлүүлэгч иргэдэд эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор урлаг, соёл, спортын салбарын нийт 25 төлөөлөл "Гэгээн өглөө" уулзалтад зочноор оролцон 1200 иргэнд өглөөний лекц уншиж, чөлөөт ярилцлага хийж ажилласан нь иргэдийн дунд хүлээлттэй, үр дүнтэй ажлуудын нэг болсон байна.	100

34	Зорилт 4.2.3. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үйлчлүүлэгч иргэдэд хөгжил төлөвшлийн олон талт сургалт зохион байгуулах.		Зохион байгуулсан сургалтын тоо	10	15	Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газар, Мэргэшсэн мэргэжил сургалтын төв, Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор төв, Улаанбаатар хотын номын сан, Анагаах ухааны доктор элэг нойр булчирхайн мэс засалч Х.Баянмөнх, Зөв найзууд ТББ, “Жоб цэнтэр”, зэрэг хувь, байгууллагуудтай хамтран үйлчлүүлэгч иргэдэд хөгжил төлөвшлийн олон талт сургалтыг 15 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 675 иргэн хамрагдсан байна.	100
35	Зорилт 4.2.4. Нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх өдрүүдийг угтсан төлөвлөгөөний дагуу үйлчлүүлэгч иргэдийн дунд өдөрлөг, спорт, соёл урлагийн үйл ажиллагаа зохион байгуулж ажиллах.		Арга хэмжээний тоо	12	15	Киноны цаг, Цагаан сар, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон Эр цэргийн баяр, Музей үзвэр, Нэгэн зүгт спорт өдөрлөг, Улсын баяр наадмыг угтан иргэдийн дунд явган аялал, Ахмад настай үйлчлүүлэгчдийг хамруулсан “Ахмадын баяр-2025” арга хэмжээ зэрэг 16 удаагийн тэмдэглэлт өдрүүд, урлаг, соён гэгээрэл, спортын өдөрлөг арга хэмжээ зохион байгуулан нийт 501 иргэн хамрагдсан байна. Эдгээр үйл ажиллагаа нь иргэд хамт олон дунд өөрийгөө зөв авч явах, нийгмийн соёл, Монгол уламжлал, ёс заншилд суралцахад эерэг нөлөөтэй, үр дүн бүхий хөтөлбөр юм.	100
4.3. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ							
36	Зорилт 4.3.1. Төвөөс үйлчилгээ авч буй иргэдэд сэтгэл зүйн анхан шатны үнэлгээ /архины хамаарлын түвшин тогтоох, сэтгэц оношилгоо/ хийж ажиллах.		Хамрагдсан иргэдийн тоо	350	700	Сэтгэл зүйн анхан шатны үнэлгээ оношилгоонд төвд шинээр ирсэн нийт 353 үйлчлүүлэгч иргэнийг хамруулан ажилласан. Үүнд шинээр ирсэн 269, сэтгэцийн өөрчлөлт ажиглагдсан 11, “Амьдралаа өөрчилмөөр байна уу?” төсөлд хамрагдсан 4, Сэтгэц нийгмийн сэргээн засах төвөөр үйлчилгээ авч байгаа 8, “Донтолтын хамаарлыг бууруулах сэтгэл зүйн хөтөлбөр”-т 20, давтан үйлчилгээ авч буй 52 үйлчлүүлэгч тус тус хамрагдсан. Үйлчлүүлэгч иргэд өөрийн архины хамаарлын түвшин, сэтгэл зүйн онцлогийг ойлгож цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нэгдсэн ойлголттой болж байгаа нь оношилгооны үр дүн юм.	100
37	Зорилт 4.3.2. Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, заслын үйлчилгээг иргэний өөрийн хүсэлтийг үндэслэн үзүүлэх.		Хамрагдсан иргэдийн тоо	220	500	Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг 343 үйлчлүүлэгч иргэнд өгч ажиллав. Үүнд төвд шинээр ирсэн 269, “Амьдралаа өөрчилмөөр байна уу?” төслийн 4, Сэтгэц нийгмийн сэргээн засах төвөөр үйлчилгээ авч байгаа 8, “Донтолтын хамаарлыг бууруулах сэтгэл зүйн хөтөлбөр”-т 20, давтан зөвлөгөөнд 42 үйлчлүүлэгч иргэн тус тус хамрагдав. Үйлчлүүлэгч иргэд сэтгэл зүйн асуудлыг томьёолж, асуудал бэрхшээлийг даван туулах, сэтгэл зүйн эрүүл мэндээ хамгаалахад суралцаж, донтолтын	92

						хамаарлаа хүлээн зөвшөөрч согтууруулах ундаанаас татгалзах сөрөг зан үйл дээрээ ажиллаж эхэлсэн нь зөвлөгөөний үр дүн юм.	
38	Зорилт 4.3.3. Төвийн түр хоноглох байраар үйлчлүүлж буй иргэдийг сэтгэл зүйн үнэлгээний дагуу бүлгийн зөвлөгөөнд хамруулах.		Иргэдийн хамрагдалтын тоо	450	700	“Архины хамаарал ба сэтгэл зүйн эрүүл мэнд” сэдэвт бүлгийн зөвлөгөөг нийт 715 үйлчлүүлэгч иргэнд өгсөн. Үүнд төвд шинээр ирсэн 143, “Амьдралаа өөрчилмөөр байна уу?” төслийн 4, Сэтгэц нийгмийн сэргээн засах төвөөр үйлчилгээ авч байгаа 8, “Донтолтын хамаарлыг бууруулах сэтгэл зүйн хөтөлбөр”-т 20, “Өөрийгөө ойлгох” бүлгийн сэтгэл зүйн хөтөлбөрт 40 үйлчлүүлэгч иргэн хамрагдсан байна.	100
39	Зорилт 4.3.4. Төвөөр үйлчлүүлэгч иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган ажиллах.		Судалгааны тоо	4	4	Төвийн үйлчилгээний чанар хүртээмжийг үнэлэх зорилгоор жилд 4 удаа нийт 138 үйлчлүүлэгч иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнэхэд төвийн үйл ажиллагааны чанар хүртээмжид судалгаанд оролцогчдын 95% нь маш сайн, хангалттай гэсэн үнэлгээ өгсөн байна. Мөн үйлүүлэгч иргэдийн санал хүсэлтийн мөрөөр ажиллаж улирал бүр тайлан гаргаж төвийн үйл ажиллагаанд тусган ажилласан.	97
4.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ							
40	Зорилт 4.4.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Нийслэлийн Цагдаагийн Удирдах Газар бусад холбогдох байгууллагуудтай хамтран гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах.		Зохион байгуулсан ажлын тоо	16	24	ГХЗУС чиглэлээр гадагшаа 2 удаа, дотооддоо 5 удаа сургалт арга хэмжээ зохион байгуулж, цахим орчин болон мэдээллийн самбарт 13 удаа мэдээлэл нийтэлж, түгээсэн. НЦУГ-ын зохион байгуулсан хэлэлцүүлэг арга хэмжээнд оролцсон. НЗДТГ, Нийслэлийн ГХУС зөвлөл, НЦУГ, СХД-ын Цагдаагийн газар, СХД-ийн орон тооны бус зөвлөл зэрэг байгууллагуудтай уулзаж, санал солилцож, хамтын ажиллагааг өргөжүүлж ажилласан. Үйлчлүүлэгч иргэдэд ганцаарчилсан 31 удаа, бүлгийн 10 удаа хууль эрх зүй, ГХЗУС чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.	84
41	Зорилт 4.4.2. Үйлчлүүлэгч иргэдийн амьдарч буй байранд хуваарийн дагуу камерын хяналт, согтууруулах, мансууруулах бодис, хүний биед гэмтэл учруулж болзошгүй эд зүйлсийн үзлэг хийж, зөрчил гаргасан иргэдэд хариуцлага тооцож ажиллах.		Зохион байгуулсан ажлын тоо	40	40	48 удаагийн хамтарсан багийн хурлаар иргэдтэй холбоотой асуудлыг хэлэлцэж, 6 удаагийн зөрчлийг хамтарсан багийн хурлаар хэлэлцэн шийдэж, эрх бүхий байгууллагад мэдэгдсэн. Үйлчлүүлэгч иргэдийн байр болон камерын хяналтыг 21 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, илтгэх хуудсаар баримтжуулж ажилласан. Түүнчлэн түр хоноглох байрны дотоод журмыг 2026 онд шинэчлэн сайжруулалт хийхээр ажиллаж байна.	88

42	Зорилт 4.4.3. Байнга архидан согтуурч, удаа дараа зөрчил гаргаж буй иргэдийг баримтад үндэслэн архины албадан эмчилгээнд хамруулах чиглэлээр дараагийн шатлалын байгууллагуудтай хамтарч ажиллах.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь		100	Удаа дараа зөрчил гаргаж буй иргэдийн талаар харьяалах цагдаагийн байгууллагад иргэдийн талаар мэдэгдэн ажилласан боловч тухайн иргэн архины албадан эмчилгээнд явуулахад тавигдах эрүүл мэнд зэрэг зарим шаардлагыг хангаагүй тул явуулах боломжгүй тайлбарууд гарсан. Иймд удаа дараа зөрчил гаргаж буй иргэдэд хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	85
4.5. Эрүүл мэндийн үйлчилгээ							
43	Зорилт 4.5.1. Үйлчлүүлэгч иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, дараагийн шатлалын эмнэлэгт зуучлах үйлчилгээ үзүүлэх.	Нийслэл ийн төсөв 9.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Төвөөр үйлчлүүлсэн 715 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн. (давхардсан тоогоор 2160 иргэн) Нийт 172 иргэнийг дараагийн шатлалын эмнэлэгт зуучлаж, хэвтэн эмчлүүлсэн байна. Үүнд: Энэрэл эмнэлэг-48, ХӨСҮТөв-15, ГССҮТөв-23, СХДНЭмнэлэг-48, ЧДНЭмнэлэг-2, БГДЭМТөв-33, ӨЭМТөв-4, СЭМҮТөв-7 иргэн тус тус үйлчлүүлсэн байна.	100
44	Зорилт 4.5.2. Үйлчлүүлэгч иргэдийн архины хамаарлын түвшинд үндэслэн архины сайн дурын эмчилгээнд хамруулах.		Хамрагдсан иргэдийн тоо	31	30	Аддиктологийн төвд 12 иргэн, Сэтгэц нийгмийн сэргээн засах төвд 16 иргэн тус тус эмчлүүлж нийт 28 иргэн архины сайн дурын эмчилгээнд хамрагдсан байна.	97
45	Зорилт 4.5.3. Үйлчлүүлэгч иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах. /эхo, дотор, мэс засал, арьс өнгө, сүрьеэ, мэдрэл, эмэгтэйчүүд/		Зохион байгуулсан үзлэгийн тоо	4	4	Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг ТББ-200 иргэн, Энэрэл эмнэлэг-123 иргэн, БГДЭМТөв-32 иргэн нийт 8 удаагийн үзлэг шинжилгээнд 355 иргэн хамрагдсан байна. Үзлэг, шинжилгээнд хамрагдсан иргэд: ЗСТ эмгэгтэй-163 иргэн, БШЗ эмгэгтэй-100 иргэн, харвалтын дараах үлдэцтэй-18 иргэн, ХБЗ эмгэгтэй-187 иргэн, архины хамааралтай-354 иргэн, тэмбүүтэй-30 иргэн, оншилогдон эдгэрч сүрьеэгийн эм ууж байгаа-4 иргэн ба шинээр оношлогдсон-6 тус тус оношилгогдсон бөгөөд сүрьеэтэй 4 иргэн ХӨСҮТөвд хэвтэж, 1 нь эмчилгээнд хамрагдаж, эдгэрэн 1 иргэн оргосон байна.	100
46	Зорилт 4.5.4. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төлөвлөгөөний дагуу ажилтнуудын хөдөлмөр аюулгүй ажиллагаа болон үйлчлүүлэгч иргэдийн амьдрах орчны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахад хяналт тавьж ажиллах.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	ХАБЭА-н ажилтан ажилтнуудын ажлын байран дээрх аюулгүй байдал, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдалд төлөвлөгөөний дагуу үзлэг шалгалт хийж, тогтмол хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан. Мөн төвийн хашаан дахь 10 гэрт байрлан үйлчилгээ авч буй иргэдэд зөвлөмж өгч, шаардлагатай 5 янданг шинээр сольж, 4 зуухыг засварт өгч сайжруулан, гэр тус бүрд угаарын хий мэдрэгч, аюулгүй ажиллагааны зааварчилгаа байршуулсан. Монголын Мянганы сорилтын сангийн хөдөлмөрийн аюулгүй байдлын	100

						зөвлөх Н.Ууганбаатарыг төв дээр урьж ХАБЭА-н талаар арга зүйн зөвлөгөө авсан. Таван толгой түлш ХХК-ийн мэргэжилтэн төвийн 2 салбар дээр ирж галын аюулгүй ажиллагааны зааварчилгаа, угаарын хий хордлогын үед авах арга зүй өгч ажилласан. Гал тогооны ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг долоо хоног бүр өгч ажилласан. Гал тогоо болон бусад объект дээр нийт 60 ширхэг аюулгүй ажиллагааны зааварчилгаа байршуулсан. Төвөөр үйлчлүүлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Дезерт ОУ-байгууллагад хүсэлт хүргүүлэн гурван тэргэнцэр олгож ажилласан байна.	
47	Зорилт 4.5.5. Иргэдийн нөхцөл байдлыг үнэлж нэн шаардлагатай иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулах.		Хамрагдсан иргэдийн тоо	20	50	Байгууллагаас нэн шаардлагатай 4 иргэнийг, ажил хийж олсон орлогоороо 36 иргэн нийт 40 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулж ажилласан.	96
48	Зорилт 4.5.6. Нөхөн сэргээх эмчилгээ бүхий чийрэгжүүлэлтийн кабинетын тогтвортой байдлыг хангаж, төвөөр үйлчлүүлж буй иргэдэд хуваарийн дагуу нөхөн сэргээх эмчилгээ, чийрэгжүүлэх үйлчилгээг үзүүлж ажиллах.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Канадын ЭСЯ, Канад сан-гийн дэмжлэгтэйгээр 2024 онд хэрэгжсэн төслийн хүрээнд байгуулагдсан “Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, нөхөн сэргээх болон физик эмчилгээний кабинет”-ийн үйл ажиллагаа тогтвортой, үр дүнтэй үргэлжилж байна. Тайлант хугацаанд нийт 607 иргэн кабинетын үзлэг, үйлчилгээнд хамрагдсан. Үүнд: Физик болон нөхөн сэргээх эмчилгээ: - УВЧ – 200 хүнд 1,000 удаагийн үйлчлэл - Инфра улаан туяа – 80 хүнд 400 удаагийн үйлчлэл - Массажны сандал – 20 хүнд 200 удаагийн үйлчлэл - Утлага – 40 хүнд 200 удаагийн үйлчлэл - Лазер эмчилгээ – 30 хүнд 150 удаагийн үйлчлэл - Гүйлтийн зам – 20 хүнд 200 удаагийн үйлчлэл - Спиннинг дугуй – 20 хүнд 200 удаагийн үйлчлэл - Лазер (давтан) – 20 хүнд 100 удаагийн үйлчлэл Уламжлалт эмчилгээ: - Хануур засал – 8 хүн - Бумба – 39 хүнд 390 удаагийн үйлчлэл - Тан эмчилгээ – 80 хүн - Төөнүүр – 20 хүнд 200 удаагийн үйлчлэл - Зүү эмчилгээ – 30 хүнд 150 удаагийн үйлчлэл Хамрагдалтаар УВЧ эмчилгээ (32.9%) хамгийн өндөр байна.	100

						Уламжлалт эмчилгээнээс тан эмчилгээ (13.2%) болон бумба (6.4%) илүүтэй сонгогдсон байна. Нийт иргэдийн 30–40% нь физик эмчилгээний өндөр давтамжтай төрлүүдийг түлхүү авсан нь эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулж байна. Гэмтэл, шарх, түлэгдэлтэй иргэдэд нөхөн сэргээх физик эмчилгээг тогтмол хяналт, үнэлгээгээр дэмжин, хувь хүний хэрэгцээнд нийцсэн эмчилгээний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж буй нь эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.	
49	Зорилт 4.5.7. Эрүүл мэндийн анхан шатны дэмжлэг үзүүлэх, хордлого тайлах төвийн төслийн баримт бичиг боловсруулах		Гүйцэтгэлийн хувь	20	100	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын зөвлөмжийн дагуу “Дотрын өвчний чиглэлээр оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх” зөвшөөрөл авах төслийн баримт бичгийг боловсруулан шаардлагатай материалын хамт цахимаар тус байгууллагад хүргүүлэн ажилласан. Түүнчлэн төвийн эрүүл мэндийн албаны эмч, сувилагч зэрэг шаардлагатай орон тооны бүрдүүлэлтийг хийж, эмчилгээ үйлчилгээ үзүүлэх өрөө тасалгааны төлөвлөлтийг хийж ажилласан. “Дотрын өвчний чиглэлээр оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх” зөвшөөрөл гарснаар иргэдэд зөвшөөрлийн хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээг илүү хүртээмжтэй байдлаар хүргэж ажиллах юм.	90
50	Зорилт 4.5.8. Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, яаралтай үед анхны тусламж үзүүлэх, бэлэн байдлыг хангах талаар үйлчлүүлэгч иргэдэд болон албан хаагчдад сургалт, дадлагажуулалд, мэдээлэл зохион байгуулж ажиллах.		Зохион байгуулсан сургалтын тоо	2	2	Төвийн сувилагч, ХАБЭА-ажилтан нар үйлчлүүлэгч иргэдэд босголт, хөлдөлт, түлэгдэлтийн, үед авах анхан шатны сургалтыг 2 удаа зохион байгуулж нийт 85 иргэн хамрагдсан. Түүнчлэн үйлчлүүлэгч иргэдэд 12 сарын 01-ны Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийг тохиолдуулан ДОХ-ын талаар сургалт зохион байгуулж нийт 84 иргэнд хамрагдсан.	100
4.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ							
51	Зорилт 4.6.1. Хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой дэмжиж, ажил олгогч болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж үйлчлүүлэгч иргэдийг ганцаарчилсан болон бүлгийн		Ажлын байранд зуучилсан иргэдийн тоо	180	250	Төвийн мэдээллийн самбарт байрлуулж буй ажлын зар болон хамтран ажилладаг байгууллагуудаас ирсэн нээлттэй ажлын байрны зарын дагуу тогтвортой ажлын байранд 69, түр ажлын байранд 96 нийт 165 иргэнийг ажлын байранд зуучилсан байна. 4 сарын 1-ний өдөр цэвэрлэгээний ажлын байранд зуучлагдсан 9 иргэнээс 1 иргэн хуримтлал үүсгэн бие	85

	зөвлөгөөнд хамруулж, ажлын байранд зуучилж, ажлын байрны тогтвортой байдлыг хангахад анхаарч ажиллах.					даасан амьдралд шилжиж, 1 иргэн ажлын байраа шилжүүлж, 3 иргэн ажлын байраа орхиж, 4 нь одоогоор тогтвор суурьшилтай ажиллаж байна. Хороонд зуучлагдсан 9 иргэн үр дүнгийн хувьд 66,6%-тай байна. Ажлын байранд зуучлагдсан нийт иргэдийн 40-50 хувь нь буруу зуршилдаа эргэн орж ажлын байраа орхисон байна. Ажилд зуучлагдаж буй иргэдийн 25-30% ажлын байраа тогтвортой хадгалж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үр дүнг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2025 онд Мэргэшсэн мэргэжил сургалтын төвтэй хамтран ажилласан нь ихээхэн үр дүнтэй байв. Тус байгууллагатай хамтран хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйлчлүүлэгч иргэдэд 3 удаа сургалт зохион байгуулж, нийт 25 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдлын үнэлгээнд хамруулан, хувь хүний хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Эдгээр иргэдээс 13 иргэн ажлын байранд зуучлагдсан байна.	
52	Зорилт 4.6.2. Сургалт хүмүүжлийн цогцолбор төвд оёдол эсгүүр, модон эдлэл, төмс хүний ногоо, жимс жимсгэнийн тариалалт, мод үржүүлгийн чиглэлээр үйлчлүүлэгч иргэдийн ажил мэргэжлийн нийцэлд суурилан сургалтад хамруулж, дадлагажуулж ажиллах.		Сургалтад хамрагдаж, дадлагажсан иргэдийн тоо	0	30	Сургалт хүмүүжлийн цогцолбор төвд шаардлагатай тоног төхөөрөмжийн тооцоо, судалгаанд оёдол, модон эдлэлийн тоног төхөөрөмжийн тооцоо, судалгаа гаргаж тусгасан. Сургалт хүмүүжлийн цогцолбор төв ашиглалтад орсноор үйлчлүүлэгч иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулах ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.	90
53	Зорилт 4.6.3. Төвийн оёдлын цехээр дамжуулан үйлчлүүлэгч иргэдийн ажлын байранд хамрагдалт, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх		Хамрагдсан иргэдийн тоо	5	10	Тайлангийн хугацаанд оёдлын өрөөг түшиглэн 5 иргэн (эмэгтэй 3, эрэгтэй 2) түр ажлын байраар хангагдаж, нийт 1,267,000₮-ний цалин олгож ажилласан байна. Төвөөс үйлчилгээ авч буй 2 иргэнийг /эмэгтэй/ 14-21 хоногийн хугацаанд оёдол, эсгүүрээр дадлагажуулж, сургаж хөгжүүлсэн. Түүнчлэн оёдлын машинд дуудлагаар 2 удаа засвар үйлчилгээ хийлгэсэн. Оёдол дээр ажиллаж буй иргэд цалингаа мэргэжлийн сургалтад хамрагдах, хуримтлал үүсгэх зэрэг зорилгодоо чиглэсэн зүйлд зарцуулсан нь төслийн үр дүн юм.	98
54	Зорилт 4.6.4. Бүх нийтийн их цэвэрлэгээ, Шарилжгүй Улаанбаатар зэрэг нийтийг		Зохион байгуулсан ажлын тоо	6	6	Нийслэлийн Засаг даргын А/354 захирамжийн дагуу 2 удаа хуваарийн дагуу төвийн албан хаагчид, үйлчлүүлэгч иргэд хамтран их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан.	100

	хамарсан ажилд иргэдийн сайн дурын оролцоог хангаж ажиллах.					Түүнчлэн 05 сарын 14-ний өдөр СХД, 24-р хороо Баруун салаа Богдын давааны ойд, иргэдийн амарч зугаалдаг талбайд их хэмжээгээр хуримтлагдсан хогийг Зөв найзууд НҮТББ-тай хамтран цэвэрлэж, ачуулсан. Түүнчлэн СХД-ийн 5, 6-р хорооны нутаг дэвсгэрт автобусны буудал, нийтийн эзэмшлийн зам талбайд 3 удаа төвийн үйлчлүүлэгч иргэд албан хаагчид хамтран сайн дурын цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан. Нийт 6 удаагийн их цэвэрлэгээний ажилд 25 албан хаагч, 150 үйлчлүүлэгч иргэн хамрагдаж, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах, цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулан ажилласан байна.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 5. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамжаар батлагдсан 2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласан ажлын хүрээнд							
55	Зорилт 5.1. Сургалт хүмүүжлийн цогцолбор төвийн орчинд “Хамтдаа тарьж, хамтдаа ургуулъя” мод тарьж ургуулах төслийг хэрэгжүүлэх.		Төслийн гүйцэтгэлийн хувь	10	60	Нийслэлийн Замын хөгжлийн газарт албан бичиг хүргүүлж ажилласнаар тус байршилд мод тарихыг дэмжиж, тус байршилд шинээр тавих авто замын зураг төслийг хүлээн авсан. Уг төслийг 2026 онд БНСУ-ын Хан мөрнийг хамгаалах хөдөлгөөний төв ТББ-тай хамтран хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Нийслэлийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай хамтран ажиллаж: Нийгмийн хамгааллын тусгай төв, БНСУ-ын Хан мөрнийг хамгаалах хөдөлгөөний төв ТББ-тай 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр харилцан хамтран ажиллах санамж бичиг байгуулан дараах чиглэлд хамтран ажиллаж байна. Үүнд: 1.Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйлчлүүлэгчдэд чиглэсэн боловсрол, хамгаалалд дэмжлэг үзүүлэх 2.Хүрээлэн буй орчныг хамгаалах, цөлжилтийг бууруулах чиглэлд: (мод тарих, ойн нөхөн сэргээлт, зүлэгжүүлэлт, сайн дурын их цэвэрлэгээ) 3.Монгол, Солонгос 2 улсын харилцан соёл, туршлага судлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	90
Стратеги төлөвлөгөөний зорилго 6. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт							
6.1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах							
56	Зорилт 6.1.1. Хариуцсан чиг үүргийн хүрээнд чиг үүргийн шинжилгээ хийж, засаглалын		Гүйцэтгэлийн хувь	-	100	Нийслэлийн ТЗУГ-аас зохион байгуулсан Улаанбаатар хотын нутгийн захиргааны байгууллагуудын өнөөгийн байдал, сайжруулах арга зам сургалтад төвөөс 3 ажилтан	100

	тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлэх.					хамрагдсан бөгөөд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын засаглалын төлөв байдлыг тодорхойлох судалгааны дагуу ажлын хэсэг байгуулан байгууллагын дотоод үнэлгээг гаргаж ТЗУГ-т хүргүүлж ажилласан.	
57	Зорилт 6.1.2. MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх.		Гүйцэтгэлийн хувь	-	100	Тусгай төвийн Түр хоноглох байрны ашиглалтын хугацаа дууссан, орчны стандарт хангагдахгүй түвшинд хүрсэн тул 2026 оноос түр хоноглох төвийн байрыг шинэчлэн стандартад нийцүүлэх ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна. Шинээр ашиглалтад орж буй Сургалт хөгжлийн цогцолбор төвийн байр нь орц гарц, хөгжлийн бэрхшээлтэй хүний зам талбай, ариун цэврийн өрөөний үйлчилгээ, агаар сэлгэлт, өрөө тасалгааны зохион байгуулалт гэх мэт орчны стандартыг хангасан тул цаашид чанарын удирдлагын тогтолцоо, үйлчилгээний олон улсын стандартыг нэвтрүүлэхийг зорьж байна. Түүнчлэн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлж буй Нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, хууль эрх зүйн 5 чиглэлд сургалтын дараах үнэлгээ, сэтгэл ханамжийн үнэлгээг стандартын дагуу, тогтмол хийж, үнэлгээний үр дүнг үйл ажиллагаандаа тусган, сайжруулалт хийж ажилладаг болох зорилтын хүрээнд шинэчлэгдэн боловсруулагдаж буй сургалт хөгжлийн цогц хөтөлбөрт тусган ажилласан.	100
58	Зорилт 6.1.3. Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх		Гүйцэтгэлийн хувь	-	100	Байгууллага дотоод хяналтын ажилтны орон тоогүй тул сүүлийн 2 жил нийгмийн ажилтан хавсран гүйцэтгэж ажилласан. 2026 оноос эхлэн Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод хяналт хариуцсан бие даасан ажилтантай болж, улирал бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр дотоод хяналтын ажлыг зохион байгуулж, байгууллагын улирал, хагас, бүтэн жилийн тайлан, урт хугацааны төлөвлөлтөд хяналт шинжилгээг стандартын дагуу хийж ажилладаг байх зохицуулалтыг бүрдүүлсэн. Цаашид хяналт, мониторингийн тогтолцооны олон улсын туршлагыг судалж, 2026 онд шинэлэг арга зүй нэвтрүүлэхийг зорьж байна.	100
59	Зорилт 6.1.4. Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг боловсруулах,		Гүйцэтгэлийн хувь	-	100	Нийгмийн хамгааллын тусгай төв нь зорилтот бүлгийн иргэдэд үзүүлдэг Нийгмийн ажил, сэтгэл зүй, хөдөлмөр эрхлэлтийн 3 чиглэлд 2015 оноос эхлэн сүүлийн 10 жил тогтмол статистик судалгааг нэгтгэн гаргаж, анализ хийж, үйл ажиллагаа, төлөвлөлтдөө тусган ажиллаж ирсэн.	98

	тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлэх.					Цаашид эрүүл мэнд, хууль эрх зүйн үйлчилгээний статистикийг нэгтгэн боловсруулалт хийж ажиллахаар чиглэл хариуцсан ажилтнуудыг зөвлөгөө арга зүйгээр ханган ажиллаж байна. Ингэснээр байгууллагаас иргэдэд үйлчилгээ үзүүлдэг үндсэн 5 жилийн судалгаа, статистик цогц болж, байгууллагын жил жилийн үзүүлэлтийг харьцуулан судлах, урт хугацааны бодлого боловсруулж, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн үр дүн, ач холбогдолтой болох юм.	
60	Зорилт 6.1.5. nhtt.ub.gov.mn цахим хуудас, төвийн нүүр номын хөтлөлтийг тогтмолжуулж, үйл ажиллагааны онцлох мэдээллийг тухай бүр мэдээлж, төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажиллах.		Мэдээллийн тоо	116	120	2025 онд нээлттэй ажлын байр, хамтын ажиллагаа, зөвлөмж контент зэрэг дотооддоо хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон дээд байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу байгууллагын nhtt.ub.gov.mn веб сайтад 135 мэдээ, фейсбүүк хуудсанд 81 мэдээ нийт 216 удаагийн мэдээ бэлтгэн нийтэлж, олон нийтэд мэдээлж ажилласан байна.	100
61	Зорилт 6.1.6. Орон гэргүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн контент боловсруулж олон нийтэд түгээн ажиллах.		Хэрэгжилтийн хувь	100	100	Төвийн сэтгэл зүйч нар сэтгэл зүйн эрүүл мэндийн талаар 2 удаагийн постор болон видео хэлбэр бүхий контент бүтээсэн бөгөөд төвийн цахим хуудас, нүүр номын хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн ажиллаж байна.	98
62	Зорилт 6.1.7. Төвийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах зорилгоор "Талархлын өдөр"-ийг зохион байгуулах.		Арга хэмжээний тоо	1	2	Төвөөр үйлчлүүлэгч иргэд, албан хаагчдыг хамруулан "Бидний өдөр" сэдвийн хүрээнд талархлын өдрийг 2025 оны 09 дүгээр сарын 24, 25, 26 өдрүүдэд зохион байгууллаа. Энэ удаагийн талархлаар үйлчлүүлэгч иргэд бие биедээ, гэр бүлдээ, төвийн үйлчилгээний албан хаагчдад хэрхэн талархаж болох сэдлийг төрүүлж, арга хэмжээг 3 өдрийн турш 98 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 88 талархал үйлчлүүлэгч иргэдээс албан хаагч, байгууллагад хандан ирснийг мэдээлж, бүртгэж ажилласан.	90
63	Зорилт 6.1.8. Байгууллагын дотоод хяналтын ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж, хэрэгжилтийг улирал бүр тайлагнах.		Хэрэгжилтийн хувь	100	100	Дотоод хяналтын жилийн ажлын төлөвлөгөө 3 чиглэлээр 19 төрлийн ажил үйлчилгээнд дотоод хяналт хийхээр батлуулж, албан хаагчдын үйл ажиллагаа, хөтөлж буй баримтад хяналтыг төлөвлөгөөт байдлаар 2, 3 дугаар улиралд дотоод хяналт хийхэд 84,7% үнэлэгдсэн байна. Хяналтын явцад ажилтнуудад зөвлөн туслах замаар ажил сайжруулах зөвлөмж өгч ажилласан.	94

64	Зорилт 6.1.9. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн ажлын төлөвлөгөөний дагуу өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, гүйцэтгэлийг хангаж ажиллах		Өмч эзэмшүүлэх гэрээний гүйцэтгэлийн хувь	85-аас дээш	90	2025 оны ажлын төлөвлөгөөний дагуу хагас жилийн эд хөрөнгө, бараа материалын тооллого хийсэн. Тооллогоор дутагдсан, илүүдсэн хөрөнгө тоологдоогүй. Ашиглалтад байсан үйлчлүүлэгч иргэдийн зөөлөн эдлэлээс ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөнжил, гудас, цагаан хэрэгслийг акталж устгасан. Дээрэт ОУБ-аас хандивласан гал тогооны тоног төхөөрөмж болон ор бусад хөрөнгүүд нийт 54,644.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхээр НӨХГ-аас зөвшөөрөл авахаар хүсэлтээ илгээсэн. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар ирсэн компьютер болон принтерийг НӨХГ-ын зөвшөөрлөөр байгууллагын даргын тушаалыг үндэслэн үндсэн хөрөнгийн дансанд бүртгүүлсэн.	100
65	Зорилт 6.1.10. Төрийн бус байгууллага, төрийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлж, “Нэгэн зүгт хамтдаа” санаачилгат өдөрлөг зохион байгуулах		Өдөрлөгийн тоо	-	1	Соёлын сарын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний дагуу “Нэгэн зүгт хамтдаа” спорт өдөрлөгийг “Найдварын өргөө” ТББ-тай хамтран зохион байгуулсан. Зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, спортын нөхөрлөл, амьдралын зөв дадлыг бэхжүүлэх зорилго бүхий энэхүү өдөрлөгийг зохион байгуулсан нь цаг үеэ олсон, үр дүнтэй ажил байв. Спорт өдөрлөгт Нийслэлийн Аддиктологийн төв, Энэрэл эмнэлэг, Нийгмийн хамгааллын тусгай төв, Тереза эх ТББ, Найдварын өргөө ТББ, Help International Mongolia зэрэг 6 байгууллагын 8 баг спортын 5 төрөлд, идэвх санаачилгатай оролцлоо. Өдөрлөгт нийт ийн зохион байгуулагчаар Нийгмийн хамгааллын тусгай төв, Найдварын өргөө ТББ хамтран ажиллав.	100
66	Зорилт 6.1.11. Алтангадас одонт Ахмад настны үндэсний төвтэй хамтарсан өдөрлөг зохион байгуулах.		Өдөрлөгийн тоо	-	1	Нийгмийн хамгааллын салбарт үйл ажиллагаа явуулдаг ижил төстэй төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцан туршлага судлах зорилгоор 2025 оны 5 дугаар сарын 7 өдөр Алтан гадас одонт Ахмад настны үндэсний төвтэй хамтарсан өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгөөр асрамжийн төвийн 1,2 дугаар төвийн үйл ажиллагаатай танилцан асаргааны 32 албан хаагчдад сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг сэтгэл зүйчид зохион байгуулсан. Мөн төвийн түр хоноглох үйлчилгээнд хамрагдаад асрамжид шилжүүлж ажилласан 15 ахмадад нийгмийн ажлын дэмжих бүлгийн уулзалт хийж,	100

						өдөрлөгөөр нийт 73 иргэнийг хамруулан зохион байгуулалт хийж ажилласан байна.	
6.2. Архив, албан хэрэг хөтлөлт							
67	Зорилт 6.2.1. Архив, албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомж, журмын дагуу хөтлөн явуулж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp, ulaanbaatar.mn, цахим хуудсыг ашиглах.		Албан бичиг шийдвэрлэлтийн хугацаа /хоног/	9	8	Тайлангийн хугацаанд нийт 175 бичиг ирснээс: Шийдвэрлэсэн: 169, Судалж байгаа: 6, Шийдвэрлэлтийн хувь: 99.13% байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног байна. Нийт 117 албан бичгийг хэвлэмэл хуудсанд стандартын дагуу буулгаж явуулсан байна.	99
68	Зорилт 6.2.2. Иргэдийн өргөдөл гомдлыг цахим болон бусад хэлбэрээр хүлээн авч шуурхай шийдвэрлэх.		Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа /хоног/	6	5	Иргэд, албан хаагчдаас 163 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч системд бүртгэж ажилласан. Үүнээс: -Шийдвэрлэсэн: 163 -Шийдвэрлэлтийн хувь: 100% байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 8 цаг 33 минут байна. Үйлчлүүлэгч иргэдээс түр хоноглох үйлчилгээнд хамрагдахыг хүссэн 873, тодорхой хугацаанд үйлчилгээ авч нийгэм сэтгэл зүй, эрүүл мэнд, ажлын байрны зуучлал хийгдэн байрнаас гарах хүсэлт 369 хүлээн авч тухай бүр нь цохолт хийн асуудлыг шийдвэрлэн ажилласан байна.	100
69	Зорилт 6.2.3. “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн хэвшиж, албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх.		Хэрэгжилтийн хувь	100	100	Монгол бичгийн стандартын дагуу тушаал-200ш, А4 албан бичиг-200ш, А5 албан бичиг-100ш, тодорхойлолт-50ш хэвлэмэл хуудсыг захиалж бүртгэл үйлдэн, зарцуулалтын мэдээг хөтлөн ажиллаж байна. Мөн 154 тушаал, 117 албан бичгийг хэвлэмэл хуудсанд стандартын дагуу буулгаж явуулсан байна.	100
70	Зорилт 6.2.4. Төвийн дарга хуваарийн дагуу үйлчлүүлэгч иргэдтэй уулзаж, санал хүсэлтийг нь сонсож, зөвлөгөө өгч ажиллах.		Уулзалтын тоо	8	8	Төвийн дарга Ахмад үйлчлүүлэгч иргэдийг удаа 2 удаа бусад иргэдийн санал хүсэлтийг 10 удаа хүлээн авч уулзсан ба давхардсан тоогоор 169 иргэдтэй уулзалт хийж, иргэдийн саналд хариу өгч, үйл ажиллагаанд уялдуулж ажилласан байна.	100

71	Зорилт 6.2.5. Тогтоол шийдвэр, захирамжийг цаг тухайд нь хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг тухай бүр тайлагнах.		Хэрэгжилтийн хувь	100	100	Тайлангийн хугацаанд eDoc системд ирсэн бичиг 175, үүнээс шийдвэрлэсэн 169, судлагдаж байгаа төлөвт 6 бичиг байна. Явсан бичиг 117 байна. Дээд байгууллагаас бичгээр болон цахимаар ирсэн тогтоол, захирамж шийдвэрийг цаг тухай бүрд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	94
72	Зорилт 6.2.6. Бичиг баримт нягтлан шалгах комиссын төлөвлөгөөний дагуу ажилтнуудын албан хэрэг хөтлөлт, бичиг баримтад стандартын дагуу зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллах.		Зөвлөгөө өгч хяналт тавих ажил зохион байгуулсан тоо	2	4	Төвийн архив бичиг хэргийн ажилтан ажилтан, албан хаагчдад - "Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг журмын дагуу бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, түүнд хяналт тавих", - "Албан хэрэг хөтлөлтийн талаар ажилтнуудын хүлээх чиг үүрэг ба eDoc программын Баримт боловсруулалт цэс ашиглах, Тоон гарын үсгийн тухай" зэрэг ажилбаруудад зөвлөгөө зөвлөмжийг тухай бүр нь өгч ажилласан. "2020-2024 оны Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд гарсан зөрчлүүдийг арилгах, цаашид хууль, журам, стандартын дагуу мөрдөж ажиллах тухай", "Улсын үзлэгтэй холбоотой" сургалтуудад давхардсан тоогоор 130 алба хаагчид хамрагдаж, зохион байгуулан ажилласан байна. "2020-2024 оны Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг 11 дүгээр сарын 3,4 тус байгууллага дээр зохион байгуулагдаж дууссан.	98
НИЙТ							94,4%

ХЯНАСАН:
ДАРГА *М. Могойдов* Ш.МӨНХЦЭЦЭГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Э.Пүрэвсүрэн
Э.ПҮРЭВСҮРЭН